## ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.12.20 Мандалговь хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Бүлэг 2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | | | |
| Зорилго 1. 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2024 онд 56-аас доошгүй хувьд хүргэнэ. | | | | | | | | | | |
| 81 | 4.1.1. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, жижиг, дунд, | 4.1.1.1. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан байгальд ээлтэй барилгын материалын үйлдвэрийг барьж ашиглалтад оруулна. | 2021 - 2025 | ХХС - 200,0 | Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо / өссөн дүнгээр/ Байнгын ажлын байрны тоо /өссөн дүнгээр/ Түр ажлын | 3<br>40<br>55 | 1<br>5<br>3 | Хувийн хэвшил - 360,0 сая.төг | Сайнцагаан сумын иргэн Д.Миеэсүрэн нь өөрийн хөрөнгөөр 300м2 Метал цонх, барилгын ханын материалыг үйлдвэрийг барьж байгуулан ашиглалтанд оруулаад байна. Цаашид шилэн хийцний үйлдвэрийг оруулж ирэхээр судалгааны шатандаа явж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөн, хүнсний үйлдвэрийн тоо 2020 онд 47 байгааг 2025 онд 57 болгоно. | | | | байрны тоо /өсөөн дүнгээр/ | | | | Байнгын ажлын байрны тоо 1, Түр ажлын байрны 4. | |
| 82 | | 4.1.1.2. Аймгийн нийт хүн амын хүнсний хэрэгцээний 65 хүртэл хувийг орон нутагт үйлдвэрлэсэн эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд хүртээмжтэй хангана. | 2021 - 2025 | 0 | Хангалтын хувь Байнгын ажлын байрны тоо | 37.80 130 | 35,1 | Хувийн хэвшил -25,0 | 2024 оны 12 сарын байдлаар орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн-216.3 тонныг үйлдвэрлэж – 9 хувийг, бууз банш-10.6 тонныг үйлдвэрлэж -2 хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн – 3,1мян.л-ийг үйлдвэрлэж - 0.09 хувийг, өндөг -67. тонныг үйлдвэрлэж 24.1 хувийг зах зээлд иргэдийн хэрэгцээнд нийлүүлж дээрх бүтээгдэхүүнээр нийт 35.1 хувийг хангасан байна. Байнгын ажлын байрны тоо 140. | 100 |
| 83 | | 4.1.1.3. Эдийн засгийн үр ашиг бүхий ажлын байр шинээр бий болгох инновацид суурилсан жижиг, дунд | 2021 - 2025 | 160 | Шинээр байгуулагдсан тоо Хөрөнгийн хэмжээ Ажлын байрын тоо | 3 100 5 | 1 300 11 | ЖДҮХСан - 300,0 сая.төг Хувийн хэвшил - 500,0 сая.төг | Энэ онд ЖДҮХСангаас 1 ААНэгжид 300,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар Ахуй үйлчилгээний нэгдсэн төвтэй болсон. Тус нэгдсэн төв ашиглалтанд орсноор | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжинэ. | | | | | | | Авто засвар, Утас завсар, Оёдол, Үсчин, гоо сайханы үйлчилгээг иргэд нэг дороос авах болно.<br><br>Хадгалагдсан ажлын байр 1, Шинэ ажлын байр 10. | |
| 84 | | 4.1.1.4. Барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2021 - 2025 | 0 | Хөрөнгийн хэмжээ Ажлын байрын тоо | 1000<br><br>6 | 12,270, 000,00 0 төгрөг<br><br>Ажлын байрн ы тоо - 819 | Банкны эх үүсвэр - 12,410, 000,000 төгрөг | Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 80-100 хувийн батлан даалттай 409 гишүүн малчинд 12,4 тэрбум олгогдсон байна.<br><br>1 ААНэгжийн Бизнесийн зээлийн батлан даалтын зээл олгогдсон. Хадгалагдсан ажлын байр-2<br>Шинэ ажлын байр-819. | 100 |
| 85 | | 4.1.1.5. Жил бүр зохион байгуулагдах ДУНДГОВЬ - ТҮНШЛЭЛ үзэсгэлэн худалдаанд зориулсан зөөврлөгддөг | 2021 - 2025 | 10 | Шинээр байгуулагдс ан тоо | 0 | | ОНТ-40,0 сая.төг рөг | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 40 ширхэг зөөврийн павилонтой болсон. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | павилонтой болно. | | | | | | | | |
| 86 | | 4.1.1.6. “Дундговь үйлдвэрлэл” зорилтот санаачилга гарган хэрэгжүүлж, Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүний г дотоод, гадаадын зах зээлд гаргах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг сум болгонд байгуулахыг дэмжинэ. | 2021 - 2025 | 100 | Байгуулагдсан хоршоодын тоо | 3 | 317 | 0 | Хулд суманд 37, Цагаандэлгэр суманд 17, Эрдэнэдалай суманд 34, Сайнцагаан суманд 98, Адаацаг суманд 49, Баянжаргалан суманд 11, Гурвансайхан суманд 24, Дэлгэрхангай суманд 6, Луус суманд 43, Өлзийт суманд 19, Дэлгэрцогт суманд 10, Дэрэн суманд 16, Өндөршил суманд 10, Сайхан-Овоо суманд 10, Говь-Угтаал суманд 17 нийт 401 хоршоо байгуулагдсан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 166 | 8.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 85-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана. | 8.3.1.1. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | 0 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ /литрээр/ | 5.7 | 11,7 | хувийн хэвшил -10,0 | Орон нутгийн үйлдвэрлэлээр Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,1 мян.л-ийг үйлдвэрлэж зах зээлд хүн амын хэрэгцээнд нийүүлсэн байна.3,1 мян.литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж 0,4 тн сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж хүн амын хэрэгцээнд стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтойгоор нийлүүлж байна. | 100 |
| 167 | | 8.3.1.2. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | 0 | Бэлтгэсэн махны хэмжээ тн | 353.7 | 470,5 | Хувийн хэвшил -1,6 тэр.бум төгрөг | Сайнцагаан сумand үйл ажиллагаа явуулж буй “Мал төхөөрөх” цэгт нийт 12,500 толгой мал төхөөрч, маханд шилжүүлснээр 237,5 тн мах бэлтгэж, аймгийн болон Улаанбаатар хотын хэрэгцээнд нийлүүлсэн байна. | 100 |
| 168 | | 8.3.1.3. МАА-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, уламжлалт болон дэвшилтэт | 2021 - 2025 | 100, 0 | Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо Байнгын | 3<br>45 | 6<br>28 | ЖДҮХСан - 780,0 | Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 2024 онд 5 ААНэгжид 730,0 сая.төгрөг, Тэмээний ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл чиглэлээр 1 ААНэгжид 50,0 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. / мах, ноос, ноолуур, арьс шир, сүү сүүн бүтээгдэхүүн ... / | | | ажлын байрны тоо | | | | сая.төгрөгийн зээлийн санхүүжилт олгогдсон. Шинээр 15, Хадгалагдсан 13 нийт 28 байнгын ажлын байр бий болсон. | |
| 169 | | 8.3.1.4. Өлзийт суманд ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж, ингэний сүүний үнэлэмжийг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | 0 | Нийлүүлсэн сүүний хэмжээ (тн) | 0 | 0 | 0 | 2021-2022 онд Өлзийт сумын 4 малчин өрхөд 1 ээлжийн 50 ингийг түрээсийн гэрээгээр маллуулж байгаад 2023 оноос эхлэн үйл ажиллагаа зогссон. 2023-2024 оны зуднаар үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон. | 73 |
| 170 | | 8.3.1.5. Дундговийн мах бодлогыг хэрэгжүүлж сумдад мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр байгуулна. | 2021 - 2025 | 0 | Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ тн Мал төхөөрөх жижиг үйлдвэрийн тоо | 1 5 | 2,5 | хувийн хэвшил -105,0 | Сайнцагаан Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулж буй “Мал төхөөрөх” цэгт нийт 12,500 толгой мал төхөөрч, маханд шилжүүлснээр 237,5 тн мах бэлтгэж, аймгийн болон Улаанбаатар хотын хэрэгцээнд нийлүүлсэн байна.Мал төхөөрөх үйлдвэрийн тоо 5. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | | 8.3.2.2. Сайхан-Овоо суманд Онги голын ус хуримтлуулах болон гүн өрмийн худаг барьж, усалгаатай тариалалтыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | 0 | талбайн хэмжээ | 0 | 20 | Хувийн хэвшил -17,0 | Сайхан-Овоо суманд үйл ажиллагаа явуулдаг “Хаан жас” хоршоонд 5 га талбайг эзэмшүүлсэн. Гүний худгийг гаргаж, малын тэжээлийн ургамлын 0,6 га-д тариалж, 0,75 тн-ийг хураан авсан байна.<br>Энэ жил нийт 14 иргэн төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал, жимс жимсгэний 7,93 га-аас 24,1 тн-ийг хураан авсан байна. | 42,6 |
| 173 | | 8.3.2.2. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн талбайн нэгжээс хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | 7,5 | Усалгаатай тариаланги йн талбайн хэмжээ га хураан авсан ургацын хэмжээ тн | 7.8<br><br>90 | 9,8<br><br>110 | Хувийн хэвшил -2,8 | Аймгийн хэмжээнд нийт 91,8 га-аас 482,4 тн-ийг ургац хурааж, урьд онтой харьцуулахад 59,6 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 174 | | 8.3.2.4. Сайнцагаан суманд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж, хүн амын хүнсний нарийн ногооны хэрэгцээг тасралтгүй хангана. | 2021 - 2025 | 8,5 | Ашиглалтын хувь хураан авсан ургацын хэмжээ тн | 40<br><br>2.8 | 100,<br><br>10,3 | ОНТ-15,6 Хувийн хэвшил-2,5 | Өвлийн нарлаг хүлэмжийн 1200 мкв талбайн ашиглалтыг бүрэн хүчин чадлаар нь 100 хувь ашиглаж, жилдээ 2 удаа 2 төрлийн тармилыг тариалж, одоогоор 11,2 тн-ийг ургац хураан авсан байна. Орон нутгийн зах зээлд борлуулсан байна. | 100 |
| 175 | 8.3.3. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн нэг малаас авах үр шимийг нэмэгдүүлэх замаар малын тоог чанарт шилжүүлэх биотехнологийн ололтыг | 8.3.3.1. Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийнэ. | 2021 - 2025 | 50 | Бойжуулсан төлийн тоо | 0 | 50 | Хувь хэвшил 5,0 | Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээс үр авч нийт 1850 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийж төл бойжилт 85 хувьтай буюу 1573 төл бойжсон.<br>энэ онд мөн 580 хонинд зохиомол хээлтүүлэг хийж нийт хээлтүүлэг хийсэн хонины тоо 2430 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 176 | нэвтрүүлэх ажил хийгдээгүй байсныг 2025 онд 3300 малд шинээр нэвтрүүлнэ. | 8.3.3.2. Олдохын хүрэн бор тэмээний тоог нэмэгдүүлэх, сумдад сайжруулагчаар ашиглаж ашиг шимийг нэмэгдүүлж хүрээг тэлнэ. | 2021 - 2025 | 30,0 | Сайжраргдсан мал болон өөр сумдад сайжруулагчаар худалдагдсан малын тоо | 570 | 720 | Хувь хэвшил 5,0 | Хулд сумын Олдохын хүрэн бор омгийн 10 хээлтүүлэгчийг шинээр тавьж Өлзийт, Дэлгэрхангай, Луус сумдад захиалгын дагуу нийлүүлж сайжруулагчаар ашигласнаар махан ашиг шим 0,1-0,2 хувиар нэмэгдэх үзүүлэлттэй байна. | 100 |
| 177 | | 8.3.3.3. Өндөршил омгийн адуу, Сайнцагаан омгийн хониноос үр авч Малын удмын сангийн үндэсний төвийн гений санд хадгална. | 2021 - 2025 | 3,0 | Генийн санд хадгалсан үрийн хэмжээ | 0 | 300 | ОН-3,0 | 2021 онд Малын үндэсний генийн санд Сайнцагаан омгийн 3 хуц, монгол үүлдрийн 3 хуцнаас 1250 тун үр, 2023 онд Өндөршил омгийн 2 азарганаас 300 тун үрийг туршилтаар авч нийт 1550 тун үрийг генийн санд хадгалуулсан.<br>Энэ онд Сайнцагаан омгийн 2 хуцыг малын үндэсний генийн төвд үр авахуулахаар хүргүүлэн, үр үйлдвэрлэлийн ажил явагдаж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 178 | | 8.3.3.4. Жилд 20-оос доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж, сумдын үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулна. | 2021 - 2025 | 1004 | Бойжуулсан бухын тоо | 974 | 210 | ОН-12,0 | Стандартын шаардлага хангасан 46 бухан бяруug шинээр тавьсан. | 100 |
| 179 | | 8.3.3.5. 3000-аас доошгүй өндөглөгчтэй шувууны аж ахуйг байгуулж, аймгийн ард иргэдийн сувиллын өндөгний хэрэгцээг хангана. | 2021 - 2025 | 0 | Өндөглөгч шувууны тоо | 0 | 3000 | ЖДҮХСан -100,0 | Жаргалант сор ХХК нь 12 мянган өндөглөгч шувуу буюу тахианы аж ахуй бий болгон аймгийн хэрэгцээг хангаж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 180 | | 8.3.3.6. Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулна. | 2021 - 2025 | 3,5 ОНТ | ээмэгжүүлж бүртгэлжүүлсэн малын тоо мян,тол | 90 | 100 | Хувь хөрөнгө-0,05 | Өндөршил, Баянжаргалан, Дэрэн суманд нийт 102 үхэр ээмэгжүүлэн. Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. | 100 |
| 181 | | 8.3.3.7. Аймгийн тэмээ өсгөх бодлогыг хэрэгжүүлж бойжуулсан ботго тутамд урамшуулал олгох системийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулна. | 2021 - 2025 | 0 | Бодлогын үр дүн | 95 | | | Хэрэгжээгүй | |
| 182 | 8.3.4. Нийт 7.4 сая га бэлчээрийн талбайн 70 хувьд | 8.3.4.1. Уламжлалт мал маллагааны аргыг сэргээх, сайн туршлагыг | 2021 - 2025 | 30,0 | Тухайн жилд хамрагдах оролцогчийн тоо | 0 | | ОНТ-20,0 | Баянжаргалан, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай, Дэрэн, Өлзийт сумдад уламжлалт мал, маллах арга | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлчээрийн даац 3 буюу түүнээс дээш дахин хэтэрч гарснаас 2025 онд 36 га талбайг нөхөн сэргээнэ. | түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Аймгийн малчдын зөвлөгөөн"-ийг жил бүр зохион байгуулна. | | | | | | | туршлагыг түгээн дэлгэрүүлэх малчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Шинэ хоршоо хөдөлгөөн, ХХСан, ЖДҮХсан, Малын тэжээлийн ургамал тариалах арга зүй, "Хүнсний аюулгүй байдлын холбогдолтой хууль тогтоомжийг танилцуулж нийт 700 малчид, иргэдэд мэдээлэл хийж, 855 ном, гарын авлага,10 постер, шторкийг гарын авлага материал тараан өгсөн. | |
| 183 | | 8.3.4.2. Бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн болон талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээнэ. | 2021 - 2025 | 10,0 | нөхөн сэргээсэн талбайн хэмжээ (га) | 0 | 7 | ДЗМОУБ-79,1 | Аймгийн Засаг даргын 2024 оны "Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг урьдчилан бэлтгэх тухай" А/330 захирамжийн дагуу малчдыг тэжээлийн ургамал тариалуулахаар 15 суманд 50,5тн овьёос, 17,5тн улаан буудайн үрийг 15 суманд хуваарилан олгож Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 75 малчин, 49,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 57,2 тонн ургац хураан авсан.<br>ДЗМОУБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн 79,3 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэдалай сумын “Далайн шим” малчдын бүлэгт 50 морьны хүчтэй трактор, дагалдах хэрэгсэл болох анжис, хөрс сийрүүлэгч, үрлэгч, хаман боогч, цахилгаан хадуур, усалгааны систем, ногоон тэжээл тариалах үр зэргийг хуваарилан олгож 5 га талбайд тэжээлийн ургамал тариалж 5тн ургац хураан авсан. Нийт 54,7 га талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тн ургац хураан авсан.<br>Нийт 54,7 га бэлчээрийн талбайг нөхөн сэргээсэн. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 184 | | 8.3.4.3. Нийт малчин өрхийн 10-аас доошгүй хувийг малын ногоон тэжээл тариалах, өвөлжөө, хаваржааны эзэмшил газарт нөөц бэлчээртэй болгож хашиж хамгаална. | 2021 - 2025 | 15,0 | Тухайн жилд тэмцсэн талбайн хэмжээ /мян га/. | 267 | 7 | Малчид-47,9 | Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Луус, Эрдэнэдалай сумдын 44 малчин өрх өвөлжөө, хаваржааны дэргэд 98,5 га талбайг хашиж хамгаалаад байна. | 100 |
| 185 | | 8.3.4.4. Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэнэ. | 2021 - 2025 | 43,8 сая | Тухайн жилд бэлчээрийн хортонтой тэмцсэн талбайн хэмжээ га | 50 | 30,0мян/га | УТ-239,7 ОНТ-14,0 | Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2024 оны А/96 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/192 дугаар захирамжийн дагуу Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой Микробиологийн аргаар тэмцэх ажлыг Улсын төсвийн 190,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай зэрэг 7 сумын 27 багийн 20,0 мянган га бэлчээрийн талбайд хийсэн Мөн аймгийн Засаг даргын А/654 дугаар захирамжаар | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | энгийн механик аргаар бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Эрдэнэдалай 4 суманд 40,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцэх ажлыг зохион байгуулж байна. Мөн дээрх сумдад шувууны үүр 100 ширхэг, утагч багаж 8 ширхэг, үлий цөмлөгч 8 ширхэгийг хуваарилан олгосон. Нийт 60 мянган га бэлчээрийн талбайд хортон мэрэгчинтэй тэмцэж бэлчээр хамгаалах ажлыг гүйцэтгэсэн.. | |
| 186 | | 8.3.4.5. Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглана. | 2021 - 2025 | 550, 0 УТХО, ОНТ, Төсөл хөтөлбөр, малчид | Сэргээгдэх эрчим хүчний тоо Тухайн жилд шинээр гаргах худгийн тоо | 3382 | 3 | УТ-94,9 сая.төг ОНТ-712,5 сая.төг, Малчид-196,8сая.төг | Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгө нийт 1.004.200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Луус, Эрдэнэдалай, Баянжаргалан, Дэлгэрцогт сумдуудад нийт инженерийн хийцтэй гүн өрмийн 18 худаг, 28 цооног, 29 энгийн уурхайн худаг сэргээсэн засварлаж 61500 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | га бэлчээрийн талбайг усжуулж, бэлчээр усжуулалтыг өмнөх оноос 0,9%-иар нэмэгдүүлсэн. | |
| ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ | | | | | | | | | | 96,6 |

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА ( гарын үсэг) Б.МӨНХЖАРГАЛ

(албан тушаал) (гарын үсгийн тайлал)

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА (гарын үсэг) Ж.ШИНЭ-УЯНГА

(албан тушаал) (гарын үсгийн тайлал)

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | га бэлчээрийн талбайг усжуулж, бэлчээр усжуулалтыг өмнөх оноос 0,9%-иар нэмэгдүүлсэн. | |
| ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ | | | | | | | | | | 96,6 |

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА ( гарын үсэг) Б.МӨНХЖАРГАЛ

(албан тушаал) (гарын үсгийн тайлал)

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА (гарын үсэг) Ж.ШИНЭ-УЯНГА

(албан тушаал) (гарын үсгийн тайлал)

16